



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

20᠑8 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/285

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Есөнбулаг сумын найман байршилд усалгааны нөөцийн сав байршуулсан ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Н.Золжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)

Гишүүд: Б Цэрэнбал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

М Мандаххуу (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

Г.Болдбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Нансалмаа (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)


Х.Батбаатар ("Хүслэнт хүдэр" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Г.Энх-Эрдэнэ (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Есөнбулаг сумын найман байршилд усалгааны нөөцийн сав байршуулах ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан ажлын даалгавар, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (А.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг даргад тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г. ЧИНБАТ